

МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛ

АГУУЛГА

1. ТӨСВИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
 - 1.1. Макро эдийн засгийн төлөв байдал
 - 1.2. Монгол Улсын 2013 оны төсвийн 9 дүгээр сарын гүйцэтгэл
2. ТӨСВИЙН ТОДОТГОЛ ХИЙХ ШААРДЛАГА, БАРИМТЛАХ ЗАРЧИМ
3. ТӨСВИЙН ТОДОТГОЛООР ХИЙГДЭХ ӨӨРЧЛӨЛТҮҮД
 - 3.1. Төсвийн нийт орлого
 - 3.2. Урсгал зардал
 - 3.3. Нийгмийн даатгалын сан
 - 3.4. Орон нутгийн төсөв
 - 3.5. Төсвийн хөрөнгө оруулалт
 - 3.6. Хүний хөгжил сан
 - 3.7. Засгийн газрын гадаад, дотоод зээл
4. ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТӨСВИЙН ТЭНЦЭЛ, ЭХ ҮҮСВЭР

1. Монгол Улсын 2013 оны төсвийн өнөөгийн байдал

1.1. Макро эдийн засгийн төлөв байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Монгол Улсын эдийн засаг 2013 оны 1 дүгээр улиралд 7.1 хувиар өсөж байсан бол Оюутолгойн зэс, алтны ордын баяжуулах үйлдвэр 2013 оны 6 дугаар сард ашиглалтанд орж, зэсийн баяжмалаа 7 дугаар сараас экспортолж эхэлсэн, Чингис бонд, Хөгжлийн банкны хөрөнгөөр авто зам болон дэд бүтцийн барилга, байгууламжуудыг барьж, Засгийн газар болон Монголбанкны хамтарсан "Үнэ тогтворжуулах хөтөлбөр"-ийн хүрээнд барилгын салбарт санхүүжилт олгож, бодит салбарын хөгжлийг дэмжсэнээр эдийн засгийн өсөлтийн хурд 2 дугаар улиралд эрчимжиж, 14.3 хувь болж өссөнөөр эхний хагас жилд эдийн засаг 11.3 хувиар өсөөд байна. 2013 оны хоёрдугаар хагаст Чингис бонд, Хөгжлийн банкны болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлуудыг үргэлжлүүлж, барилга, угсралтын ажил 2013 онд 2.6 дахин нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.

Мөн Оюутолгойн баяжуулах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж, Тавантолгойн Баруун болон Зүүн цанхийн олборлолтыг нэмэгдүүлснээр экспорт өсөх төлөвтэй байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 2013 оны эхний хагас жилд 20.6 хувиар өсөхөд 14.9 сая төл бойжуулсан нөгөө талаар 2010-2012 онд хүлээн авсан 10-13.5 сая төл мал нас дэвшиж, сүргийн эргэлтэд өөрчлөлтөд орсон нь ийнхүү өсөхөд голлон нөлөөлөв. Энэ намар цаг агаар харьцангуй тааламжтай, зүй бус хорогдол багатай байж, тариалсан ургацаа алдагдал багатай хураан авбал хөдөө аж ахуйн салбар 16 хувиар өсөх бололцоотой байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2013 онд нийт дүнгээр 14.8 хувиар өсч, дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр 17.0 их наяд төгрөгт хүрэхээр байна.

Гадаад худалдаа: Гадаад худалдааны бараа эргэлт 2013 оны эхний 8 сарын байдлаар 7.6 хувиар буурч, гадаад худалдааны тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 235.0 сая ам.доллараар буурч 1.6 тэрбум ам.доллар болсон. Экспортын хэмжээ энэ оны эхний 8 сарын байдлаар өмнөх оноос 6 хувиар буурч, 2.7 тэрбум ам.долларт хүрэв. Экспортын бууралтад нүүрсний экспорт биет хэмжээгээр 21 хувиар буурч, 9.6 сая тонн-д хүрсэн, нөгөө талаар нүүрсний үнэ 30 орчим хувиар буурсан нь голлон нөлөөлөв. Харин боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт өмнөх оны мөн үеэс 1.0 тонн алтаар нэмэгдсэн, газрын тосны экспорт 2.6 сая баррельд хүрч, төмрийн хүдрийн экспорт 17.7 мянган тонноор тус тус нэмэгдсэн байна.

Импортын хэмжээ 2013 оны эхний 8 сарын байдлаар 8.6 хувиар буурч, 4.2 тэрбум ам.долларт хүрээд байна. Импортын бууралтад машин, тоног төхөөрөмж, түлш, шатахуун, төмөрлөгийн бүтээгдэхүүний импорт буурсан нь голлон нөлөөлжээ.

Оюутолгойн ордын зэсийн баяжмал экспортод гарч, нүүрсний экспортын хэмжээ оны сүүлийн хагаст нэмэгдсэнээр экспортын орлого 2013 онд өмнөх оноос 7 орчим хувиар өсөхөөр байна. Харин нүүрс болон төмрийн хүдрийн олборлолт өнгөрсөн оны түвшингээс бууралттай байгаагийн улмаас түлш, шатахууны импорт 9-10 хувиар буурахаар байна. Мөн Оюутолгойн баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж 2010-2012 онд импортоор орж, нийт импортыг огцом өсгөж байсан бол 2013 онд импортын тоног төхөөрөмж бууралттай байхаар байна. Үүнээс хамаарч 2013 онд импорт 6 орчим хувиар буурч, гадаад худалдааны алдагдлын хэмжээ 2012 оноос 30 орчим хувиар буурч, 1.6 тэрбум ам.доллар болох төлөвтэй байна.

Инфляци: Хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцийн түвшин 2012 оны эцэст 14.2 хувь байсан бол 2013 оны 8 дугаар сарын байдлаар оны эхнээс 6.7 хувьтай байна. Сүүлийн жилүүдийн инфляцийн түвшинг авч үзэхэд нийлүүлэлтийн болон зардлын гаралтай инфляци давамгайлж байгаа нь харагдаж байна. Иймд Засгийн газраас инфляцийн түвшнийг бууруулж, тогтворжуулах бодлого баримтлан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2012 оны сүүлээр Монголбанк, Засгийн газар хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Үнэ тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах”, “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах”, “Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах”, “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” гэсэн 4 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрийн үр дүнд инфляцийн түвшинг 2013 оны эцэст нэг оронтой тоонд байлгах аар зорьж байна.

1.2. Монгол Улсын Нэгдсэн төсвийн өнөөгийн байдал

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг **7,088.3** тэрбум төгрөг (ДНБ-ий 40.3 хувь), нийт зарлагыг **7,444.6** тэрбум төгрөг (ДНБ-ий 42.2 хувь) тус тус байхаар тооцож төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 356.3 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувь байхаар баталсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 94.7 хувийн, нийт зарлага 78.1 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт тэнцэл 130.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Монгол Улсын төсвийн 2012 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 43.1.2-т заасны дагуу энэ оны 3 дугаар сарын 31-нийг хүртэл нийт 190.9 тэрбум төгрөгийг зарцуулан 2012 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмж тусгасан юм.

Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2013 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 3,936.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 5.3 хувиар буюу 222.0 тэрбум төгрөгөөр дутуу биелж, өмнөх оны мөн үеийнхээс 12.9 хувиар буюу 450.0 тэрбум төгрөгөөр илүү байна.

Төсвийн орлогын тасалдалд үндсэн хоёр шалтгаан нөлөөлсөн байна. Үүнд:

- Эхний 8 сарын байдлаар нийт импорт 4,256.9 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 8.6 хувиар буурав.
- Гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ болон биет хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс доогуур байгаа нь аж ахуйн нэгжийн ашигт ажиллагаанд нөлөөлж, орлогын албан татвар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөсөн хэмжээнд төвлөрөх боломжгүй болов.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 88.3 хувь нь татварын орлогоор, 11.7 хувь нь татварын бус орлогоор тус тус бүрдсэн биелэлттэй байна. Эхний 9 сарын байдлаар Тогтворжуулалтын санд 37.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2013 оны 9 дүгээр сарын байдлаар 5,208.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 4,067.6 тэрбум төгрөгийн буюу 78.1 хувийн, улсын төсвийн зарлага 3,997.7 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 3,171.3 тэрбум төгрөгийн буюу 79.3 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

- Улсын төсвийн халамжийн сангаас алдар цолтой ахмад дайчдын тэтгэмжид 4.5 тэрбум, алдарт эхийн одонтой эхчүүдэд 30.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Хотын нийтийн тээврийн татаас 40.9 тэрбум, эрчим хүч, дулааны алдагдлын татаас 24.6 тэрбум, улаан буудай, махны татаас 21.1 тэрбум, засгийн газрын нөөц хөрөнгийн зардал 15.2 тэрбум, их дээд сургууль коллежийн оюутны тэтгэлэг 63.0 тэрбум, хөрөнгийн зардал 629.3 тэрбум төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна. Улсын төсвөөс 113.8 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 583.4 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 112.3 тэрбум төгрөгийн ОН-ийн хөгжлийн сангийн шилжүүлгийг тус тус орон нутагт олгоод байна.
- Орон нутгийн төсвийн зарлага 1,109.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 73.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгаас улсын төсөвт 8.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 29.1 хувийн биелэлттэй байна.
- Хүний хөгжил сангийн зарлага 204.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 98.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас хүүхдэд олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 168.6 тэрбум, иргэн бүрт олгох 21000 төгрөгийн санхүүжилтээр 27.4 тэрбум төгрөгийг тус тус олгоод байна.
- Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 97.9 хувийн буюу 785.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 65.9 тэрбум төгрөгийг татаасыг олгосон байна.

Төсвийн тэнцэл:

Оны эхний 9 сард Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 130.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн нийт тэнцэл 466.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

2. Төсөвт тодотгол хийх шаардлага, баримтласан зарчим

2.1. Төсөвт тодотгол хийх үндэслэл

Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого **7,088.3** тэрбум төгрөг, тогтворжуулалтын сангийн орлого **169.8** тэрбум төгрөг, нийт орлого ба тусламжийн дүн **7,258.1** тэрбум төгрөг байхаар УИХ-аар батлагдсан.

Нэгдсэн төсвийн 2013 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг энэ оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, гадаад болон дотоод эдийн засгийн нөхцөл байдал, экспортод гарах эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээ зэрэг үзүүлэлтэд үндэслэн тооцоход 2013 оны нэгдсэн

төсвийн тэнцлийн алдагдал ДНБ-ий -6.8 хувьд хүрэхээр байгаа нь Төсвийн тухай хуулийн 34.1.2 зүйлийн “Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиар нэмэгдэх тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ” гэсэн заалтын дагуу 2013 оны төсөвт тодотгол хийх нөхцөлийг үүсгэж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг хангаж байхаар энэ оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй уялдуулан тооцоход энэ оны төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,289.1 тэрбум төгрөг болж, батлагдсан төсвөөс 799.2 тэрбум төгрөгөөр, нийт зарлага 6,629.8 тэрбум төгрөг болж батлагдсан төсвөөс 814.8 тэрбум төгрөгөөр тус тус буурч нийт алдагдал 340.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэж байгааг үндэслэн Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг боловсрууллаа.

2.2. Төсөвт тодотгол хийхэд баримтласан зарчим

Төсвийн орлогын гүйцэтгэлд дараах хүчин зүйлс голлох нөлөө үзүүлэхээр байна. Үүнд:

1. Эдийн засгийн өсөлт;
2. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт;
3. Импортын бууралт;
4. Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах асуудал шийдэгдээгүй.

Нэг. Эдийн засгийн өсөлт: 2013 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 11.3 хувьд хүрч сүүлийн хагас жилд бага зэрэг сэргэх хандлага ажиглагдаж байгаа боловч төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй байна.

Гадаад болон дотоод эдийн засгийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй байгаа нь манай улсын экспорт, импортын хэмжээ тогтворжих цаашлаад буурахад нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.

График. Оны үнээр илэрхийлсэн ДНБ-ий өсөлт





График. Ам.долларын жилийн дундаж ханш



Хоёр. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт: Манай улсын нийт экспортын 90 орчим хувь, төсвийн орлогын 20 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт эзэлдэг бөгөөд гадаад зах зээлийн таагүй нөлөөллөөс эдгээр бүтээгдэхүүнээс төсөвт төвлөрөх орлого шууд хамаарч байна.

Евро бүс, Америкийн Нэгдсэн Улсын эдийн засгийн хямралтай байдал болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын зүгээс явуулж буй дотоодын эдийн засгийн өсөлтөө царцаах бодлогоос хамаарч тус улсын ДНБ-ий өсөлт сүүлийн жилүүдэд тогтмол багасах хандлагатай байгаа нь манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний эрэлтийг бууруулж төсвийн орлогод гадаад зах зээлээс үүдэлтэй гол эрсдэлийг учруулж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гол хэрэглэгч болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2013 оны нэгдүгээр улиралд 7.7 хувь, хоёрдугаар улиралд 7.5 хувь болж, 2008-2009 оны санхүүгийн хямралаас хойшхи хамгийн бага хэмжээндээ хүрээд байна.

График. Эрдэс бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт /2000 оны зэрэгцүүлсэн үнэ/





График. Нүүрсний экспортын хэмжээ




Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын зүгээс нүүрсний нийлүүлэлтийг эн тэргүүнд бодлогоор дэмжиж байгаа болон нүүрс нийлүүлэгч улсуудын хооронд өрсөлдөөн ихсэж байгаа нь манай улсаас тус улсад экспортлох нүүрсний үнийн өрсөлдөх чадварыг сулруулж болзошгүй байна. 2013 оны 8 дугаар сарын байдлаар БНХАУ-ын нийт нүүрсний импорт 213.0 сая тоннд хүрсэнээс 4.5 хувийг нь манай улсаас нийлүүлсэн байна.

БНХАУ-ын нүүрсний эрэлт тогтмол өсч буй боловч Монгол Улсын нүүрсний экспортын хэмжээ энэ оны эхний 8 дугаар сард 9.5 сая тонн буюу 2012 оны мөн үетэй харьцуулбал 22.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

БНХАУ-ын зах зээл дээрх нүүрсний эрэлт, үнийн бууралтаас шалтгаалан нүүрсний экспортын хэмжээ 2013 оны батлагдсан төсөвт тусгагдсан хэмжээнд хүрэхээргүй болж байна. Нүүрсний экспортын хэмжээг 28.0 сая тонн байхаар тооцсон боловч энэ оны эцэст 7.5-10.3 сая тонноор буурч, 17.7-20.5 сая тонн болох төлөвтэй байна.


График. 2000-2013 оны зэсийн үнэ, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Лондонгийн металлийн бирж(<http://www.lme.com/copper.asp>)

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар гол нэр төрлийн эрдэс баялаг болох зэсийн зах зээлийн үнийг 8,152.0 ам.доллараар тооцсон боловч 2013 оны эхний 8 сарын байдлаар зэсийн үнэ дунджаар 7,508.9 ам.доллар болж буураад байна. Цаашлаад энэ оны үлдэх хугацаанд зэсийн үнэ дунджаар 7,181.9 орчим ам.доллар байх төлөвтэй байгаа нь 2013 оны батлагдсан дүнд хүрэх боломжгүй нөхцөл байдал бий болоод байна. Иймд 2013 оны тодотгосон төсвийн төсөлд зэсийн зах зээлийн үнийн төсөөллийг шинэчлэн 7,399.9 ам.доллар байхаар тооцож тусгалаа.

График: Нүүрсний үнэ, ам.доллар/тн¹



Эх үүсвэр: Сангийн яам, Уул уурхайн яам

Мөн гол нэр төрлийн эрдэс баялгийн нэг болох боловсруулсан нүүрсний үнийг 161.2 ам.доллараар тооцсон бөгөөд энэ оны эхний 8 сарын байдлаар боловсруулсан нүүрсний үнэ өмнөх онтой харьцуулахад 33.5 хувь (145.2 ам.доллараас 96.5 ам.доллар болж буурсан)-иар буюу 48.7 ам.доллараар доогуур байгаа болон ирэх саруудын үнийн төсөөлөл улам буурах хандлагатай байна. 2013 оны тодотголоор нүүрсний үнийг дунджаар 50.7 ам.доллараас 94.3 ам.доллар байхаар тооцлоо.

¹ Баяжуулсан нүүрсний үнийг 2010 оны 5 дугаар сараас зарлаж эхэлсэн.

Хүснэгт: Эрдэс бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээний төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэл /тэрбум.төг/

Бүтээгдэхүүний нэр төрөл	Үнэ			Тоо хэмжээ		
	Төлөв	Эхний 8 сар	ХБГ	Төлөв	Эхний 8 сар	ХБГ
Алт /тн/	\$1,751.0	\$1,481.6	\$1,464.6	19.5	5.5	13.2
Нүүрс /сая.тн/	\$83.17-\$161.2	\$50.6-\$96.5	\$50.7-\$94.3	28.0	9.6	20.5
Зэсийн баяжмал /мян.тн/	\$8,152.0	\$7,508.9	\$7,399.9	945.0	395.5	694.3
Цайрын баяжмал /мян.тн/	\$2,216.4	\$1,936.3	\$1,922.3	55.4	86.0	111.7
Төмрийн хүдэр /сая.тн/	\$151.9	\$119.9	\$120.7	9.9	4.3	6.0
Жонш, жоншны баяжмал /мян.тн/	\$50-\$355	\$267-\$384.7	\$209.8-\$358.8	571.9	221.3	287.7

Иймд зэс, нүүрсний үнийн бууралт болон экспортын хэмжээний бууралтаас шалтгаалан эдгээр бүтээгдэхүүний орлогоос төсөвт төвлөрөх орлогыг бууруулан тооцлоо. Мөн зэс, нүүрснээс гадна 2013 онд нийт 9.9 сая тонн төмрийн хүдэр олборлохоор төлөвлөж байсан боловч эхний 8 сарын байдлаар 4.3 сая тонн олборлосон бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 6.0 сая тонн төмрийн хүдэр олборлох төлөвтэй байгаа нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого буурахад нөлөөлж байна.

Гурав. Импортын бууралт: Нийт импортын хэмжээг эдийн засгийн өсөлттэй уялдуулан 2013 онд 9.6 тэрбум ам.доллар байхаар тооцсон боловч энэ оны эхний 8 сарын байдлаар 4.2 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн импортлоод байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.6 орчим хувиар буурч оны эцэст төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй байна.

Монгол Улсын импортын хэмжээг сүүлийн 10 жилийн хугацаанд судалж үзэхэд 2004-2008 онд үүссэн барилгын салбарын огцом өсөлт болон уул уурхайн төсөл арга хэмжээ эрчимжсэн зэрэг нь түүнийг дагасан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын зориулалттай нэг удаагийн шинжтэй импортын өсөлт 2010, 2011 онд хамгийн дээд түвшинд хүрэхэд гол хүчин зүйл нь болсон байна. Үүний дотор Оюутолгой төсөлтэй холбоотой бүтээн байгуулалтын ажлаас импортын хэмжээ огцом өссөн байна.

Нийт импортын хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дунджаар 40 орчим хувиар өсч байсан бол 2012 онд 9.7 хувьд хүрч өмнөх оны эрчимтэй өсөлт саарсан байна. Түүнчлэн энэ оны эхний 8 сарын байдлаар импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар буурч байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралттай холбоотойгоор уул уурхайн салбарын бүтээн байгуулалт, бизнесийн үйл ажиллагаа удааширсантай холбоотой юм.

Иймд импортоос хамаарах нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн албан татвар, онцгой албан татварын орлого бууруулахаар тооцлоо.

Дөрөв. Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах асуудал шийдэгдээгүй: Оюу толгой төслийн Хөрөнгө хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах

асуудал өнөөг хүртэл шийдэгдээгүйн улмаас 2013 оны нэгдсэн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон 445.7 тэрбум төгрөг, үүнээс улсын төсөвт оруулах 290.9 тэрбум төгрөг, Хүний хөгжлийн санд оруулах 154.8 тэрбум төгрөгийн орлого тус тус тасрахаар байна.

Эдийн засгийн дээрх нөхцөл байдал болон Монгол Улсын төсвийн орлогын эхний 8 сарын гүйцэтгэлтэй уялдуулан 2013 оны батлагдсан төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлагатай болж байна.

3. Тодотголоор хийгдэх өөрчлөлтүүд

3.1. Төсвийн орлого

Төсвийн тогтворжуулалтын сан

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.1 дэх заалтын дагуу 2013 онд Төсвийн тогтворжуулалтын санд нийт 169.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсоноос энэ оны эхний 8 сарын байдлаар 34.2 тэрбум төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 48.9 тэрбум төгрөг төвлөрөхөөр байна.

Нүүрсний зах зээлийн үнэ тэнцвэржүүлсэн үнээс буурч тонн тутам 50.7-94.3 ам.долларт хүрсний улмаас Тогтворжуулалтын санд нүүрснээс төвлөрүүлэхээр төлөвлөсөн 66.0 тэрбум төгрөгийн орлого энэ онд буурах төлөвтэй байна. Мөн зэсийн зах зээлийн үнэ энэ оны эхний 8 сарын байдлаар 7,508.9 ам.доллар буюу төлөвлөсөн дүнгээс 8 хувиар буурснаас шалтгаалан зэсээс төвлөрүүлэхээр тооцсон орлого энэ онд буурахаар байна.

Хүснэгт 2: Тогтворжуулалтын сангийн орлого, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Бүтээгдэхүүний нэр төрөл				Нийт дүн	
	Нүүрс		Зэсийн баяжмал			
	Төл	ХБГ	Төл	ХБГ	Төл	ХБГ
Биет хэмжээ /тонн/	28.0 сая	20.5 сая	945.0 мянга	694.3 мянга	-	
Тэнцвэржүүлсэн үнэ	\$131.5; \$80.2; \$65.5		\$ 6,328.90		-	
Зах зээлийн үнэ	\$161.2; \$96.7; \$83.17	\$94.3; \$66.6; \$50.7	\$ 8,152.0	\$ 7,399.9	-	
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	18.11	-	19.90	7.5	38.03	7.5
Ашиг малтмалын нөөц ашигласны төлбөр	27.58	-	27.75	13.2	55.33	13.2
Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр	20.3	-	56.11	28.1	76.40	28.1
Тогтворжуулалтын санд төвлөрөх орлогын дүн	65.99	-	103.77	48.9	169.7	48.9

Иймд зэс, нүүрсний зах зээлийн үнийн бууралттай уялдуулан Төсвийн тогтворжуулалтын сангийн төлөвлөсөн орлогыг 120.8 тэрбум төгрөгөөр бууруулан 48.9 тэрбум төгрөг төсвийн тодотголд тусгалаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Орлогын бууралт: Төсвийн тодотголын төсөлд нэгдсэн төсвийн нийт орлогыг **1,016.7** тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцож байна. Үүнд:

- Нийт импортын бууралтаас шалтгаалан төсвийн орлого 354.8 тэрбум төгрөг;
- Нийт экспортын бууралтаас шалтгаалан төсвийн орлого 146.5 тэрбум төгрөг;
- Өмч хувьчлалын орлого болон ус, рашааны нөөц ашигласны төлбөр зэрэг бусад нөлөөллөөс үүдэлтэй төсвийн орлого 515.3 тэрбум төгрөг;

Импортоос хамааралтай орлогын нийт бууралт

Импортын бууралтаас хамааралтайгаар төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 354.8 тэрбум төгрөгөөр бууруулан тооцлоо.

Импортоос хамаарсан орлогын бууралтын 40.0 хувь буюу 142.1 тэрбум төгрөгийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 16.5 хувь буюу 58.7 тэрбум төгрөгийг гаалийн албан татвар, 30.2 хувь буюу 107.2 тэрбум төгрөгийг автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар, үлдэх хувь буюу 46.9 тэрбум төгрөгийг суудлын автомашины онцгой албан татвар, автобензин, дизелийн албан татвар, гаалийн байгууллагын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Импортын барааны тоо хэмжээний бууралтаас хамааран 2013 оны төсвийн тодотголоор импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараар 1,117.4 тэрбум төгрөг, гаалийн албан татвараар 516.4 тэрбум төгрөг тус тус улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

Харин автобензин, дизелийн түлшний импортын албан татварын хувьд тоо хэмжээний бууралтаас гадна хувь хэмжээний өөрчлөлт давхар нөлөөлж байна. Оросын Холбооны Улсаас импортлодог автобензин, дизель түлшний хилийн үнэ болон нийлүүлэлттэй уялдуулан автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлогыг 107.2 тэрбум төгрөгөөр бууруулж, 47.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцлоо.

Суудлын автомашины онцгой албан татварын хувьд 2013 оны эхний 8 сард 19.5 мянган ширхэг суудлын автомашин импортлож, 76.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрөөд байгаа бөгөөд суудлын автомашины импорт өнгөрсөн оны мөн үеэс 1,274 тоо ширхэгээр буурсантай холбоотойгоор 6.1 тэрбум төгрөгөөр уг татвар буураад байна. Мөн онцгой албан татварын тухай хуулийн дагуу хос хөдөлгүүртэй суудлын автомашины албан татвар чөлөөлөгддөг болсноор сүүлийн жилүүдэд хос хөдөлгүүртэй суудлын автомашины импортын тоо хэмжээ өсч байгаа тул 2013 оны төсвийн тодотголоор онцгой албан татвар ногддог суудлын автомашины тоог 8.8 мянган ширхэгээр буюу 41.8 тэрбум төгрөгөөр бууруулж тооцлоо.

Экспортоос хамааралтай орлогын нийт бууралт

Экспортын бууралтаас хамааралтайгаар төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 146.5 тэрбум төгрөгөөр бууруулан тооцлоо.

Экспортоос хамаарсан орлогын бууралтын 65.5 хувь буюу 96.0 тэрбум төгрөгийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, 5.1 хувь буюу 7.5 тэрбум төгрөгийг агаарын бохирдлын төлбөр, 11.8 хувь буюу 17.3 тэрбум төгрөгийг ногдол ашгийн орлого, үлдэх хувь буюу 25.7 тэрбум төгрөгийг гаалийн байгууллагын тэмдэгтийн хураамж тус тус эзэлж байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны болон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн хувьд дэлхийн зах зээл дэх гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүний үнийн бууралт, тоо хэмжээний бууралтаас хамааран 96.0 тэрбум төгрөгөөр багасч, 2013 оны төсвийн тодотголд нийт 470.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрнө гэж тооцлоо. Нийт орлогын 295.1 тэрбум төгрөг нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, 175.3 тэрбум төгрөгийн өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр юм.

Агаарын бохирдлын төлбөрийн орлогоор 30.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон бөгөөд нүүрсэнд ногдуулж буй агаарын бохирдлын төлбөр нүүрсний экспортын бууралтаас шалтгаалан төлөвлөснөөс 7.5 тэрбум төгрөгөөр буурч, 22.5 тэрбум төгрөг болохоор байна.

Ногдол ашгийн орлогын хувьд орон нутгийн өмчит “Таван толгой” ХК-ий экспортолсон нүүрсний тоо хэмжээ эрс буурч, компаний ашигт ажиллагаа төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, мөн бусад төрийн өмчит байгууллагын ашигт ажиллагаа буурсан тул ногдол ашгийн орлогын төлөвлөгөө 17.3 тэрбум төгрөгөөр буурч байгаа болно.

Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлдэг тэмдэгтийн хураамжийн орлогын 87 хувь нь уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспортоос үлдсэн хувь нь бусад бараа бүтээгдэхүүнээс бүрддэг байна. Экспортлох бүтээгдэхүүний тоо хэмжээний бууралтаас шалтгаалан улсын тэмдэгтийн хураамжийг 25.7 тэрбум төгрөгөөр бууруулж, 44.5 тэрбум төгрөг болгон тодотгож байна.

Бусад орлогын бууралт

Өмч хувьчлалын орлогын хувьд 2013 оны төсөвт тусгасан томоохон төрийн өмчит компаниудын хувьчлалын зохион байгуулалтын ажил төлөвлөсөн хугацаанд зохион байгуулагдаагүй байна. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд “Монголын цахилгаан холбоо” ХК-ны өмч хувьчлалын орлогоор 15.7 тэрбум төгрөг, “УБЦТС” ТӨХК-ны өмч хувьчлалын орлогоор 1.5 тэрбум төгрөг, “Улаанбаатар авто зам засвар арчлалт” ТӨХК-ний хувьчлалын орлогоор 1.0 тэрбум төгрөг нийтдээ 18.2 тэрбум төгрөг төлөвлөсөн хэдий ч хувьчлалын орлого төвлөрөх боломжгүй болоод байна.

Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хувьд “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Оюу толгой” ХХК зэрэг гол орлого төвлөрүүлэгч байгууллагууд усны хэрэглээгээ бууруулах, хэрэглэсэн усыг дахин ашиглах, дахин ашигласан усны төлбөрийг хуулийн дагуу чөлөөлүүлэх замаар төлөх татвараа бууруулж байгаатай холбоотой. Мөн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу Засгийн газар усны нөөц ашигласны төлбөр тооцох суурь үнэлгээнд хамаарах усны ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг баталсан нь усны төлбөрийн орлого буурахад нөлөөллөө. Иймд усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 12.5 тэрбум төгрөгийг бууруулж, 2013 оны төсвийн тодотголд 40.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцлоо.

Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого энэ оны 8 дугаар сарын байдлаар 349.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 47.9 тэрбум төгрөгөөр өссөн байгаа боловч нийт импортын бууралттай холбоотойгоор төлөвлөсөн хэмжээнд хүрэх боломжгүй байна. Иймээс 2013 оны төсвийн тодотголд дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварыг 33.3 тэрбум төгрөгөөр бууруулан тооцлоо.

Оюу толгой төслийн Хөрөнгө хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах асуудал өнөөг хүртэл шийдэгдээгүйн улмаас 2013 оны нэгдсэн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон 445.7 тэрбум төгрөг, үүнээс улсын төсөвт 290.9 тэрбум төгрөг, Хүний хөгжлийн санд 154.8 тэрбум төгрөгийн орлого буурахаар байна.

Монголбанкнаас төвлөрүүлэхээр тооцсон 5.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрөхгүй байхаар тооцож төсвийн тодотголын төсөлд хасч тооцлоо.

Нэмэгдэх боломжтой орлого: Төсвийн тодотголын төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг **217.4** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцлоо. Үүнд:

Импортын архи, тамхины онцгой албан татвар: 2013 оны эхний 8 сарын байдлаар импортоор оруулсан согтууруулах ундааны тоо хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар өсч 7.1 тэрбум төгрөгийн татварын орлого нэмэгдэж орсон байна. Янжуур тамхи, дүнсэн тамхины татварын орлого мөн 23.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Иймд энэ оны тодотголоор импортын архи, тамхины онцгой албан татвараар улсын төсөвт 91.0 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөсөн хэмжээнээс 9.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Газрын тосны орлого: Газрын тосны орлого энэ оны эхний 8 сарын байдлаар өмнөх оныхоос 117.0 хувиар буюу 53.4 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүнд боловсруулаагүй газрын тосны хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 42.2 хувиар өсч 3,052.3 мянган баррель хүрсэн нь нөлөөлсөн байна. Энэ онд газрын тосны орлогоор 145.9 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрөхөөр батлагдсан бөгөөд 2013 оны тодотголоор газрын тосны олборлолтын хэмжээ 4.8 сая баррельд хүрч, улсын төсөвт 161.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцлоо. Энэ нь энэ оны батлагдсан төсвөөс 15.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Навигацийн орлого: Улсын төсөвт төвлөрүүлэх навигацын орлого нь өнгөрөлтийн тоо хэмжээ, валютын ханш болон нэг нислэгт ногдох орлогоос шууд хамаардаг тул 2013 оны тодотголоор улсын төсөвт 58.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцсон нь батлагдсан төсвөөс 7.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Нийгмийн даатгалын орлого: Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 2013 оны 8 дугаар сарын байдлаар 834.5 тэрбум төгрөгт хүрсэн нь сарын төлөвлөгөөнөөс 69.5 тэрбум төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байдалтай байна. Тиймээс тус сангийн орлогыг нэмэгдүүлснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 94.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Хувь хүний орлогын албан татварын болон хувь хүний орлогын албан татварын буцаан олголт: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу орон сууц худалдан авах, хүүхдийнхээ болон өөрийн сургалтын төлбөрт төлсөн татварыг буцаан авахаар хуульчилсны дагуу төсөвт 29.2 тэрбум төгрөгийн буцаан олголт олгохоор төлөвлөсөн. Гэвч бодит байдал дээр

24.2 тэрбум төгрөгийн татварын буцаан олголт тайлангаар гарсан тул 5.0 тэрбум төгрөгийн буцаан олголтыг хасч, төсвийн орлогод нэмэлт эх үүсвэр бий болохоор тусгалаа.

Үл хөдлөх хөрөнгийн албан татвар болон хог хаягдлын үйлчилгээний хураамж: Орон нутгийн үл хөдлөх хөрөнгийн албан татвар болон хог хаягдлын үйлчилгээний хураамжийг энэ оны 8 дугаар сарын гүйцэтгэлд үндэслэн 2.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тооцлоо.

Хүү торгуулийн орлого болон бусад орлого: Төрийн сангийн дансны үлдэгдэлд ногдох хүүгийн орлого Чингис бондын хөрөнгийн байршуулалттай холбоотойгоор 71.2 тэрбум төгрөгөөр, орон нутгийн хүү торгуулийн орлого 4.0 тэрбум төгрөгөөр нийтдээ 75.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого: Улсын төсөвт орлого төвлөрүүлэгч төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг 5.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тооцлоо.

Энэхүү орлогын нэмэлт өөрчлөлтийг оруулснаар 2013 оны батлагдсан нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 920.0 тэрбум төгрөгөөр буурах, нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 799.2 тэрбум төгрөгөөр буурахаар төсвийн тодотголын төсөлд тооцож тусгалаа.

3.2. Урсгал зардал

Төсвийн урсгал зардлын 2013 оны эхний 9 сарын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2013 оны 9 дүгээр сарын байдлаар 5,208.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 4,067.6 тэрбум төгрөгийн буюу 78.1 хувийн, улсын төсвийн зарлага 3,997.7 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 3,171.3 тэрбум төгрөгийн буюу 79.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт-1. Нэгдсэн төсвийн нийт зарлагын эхний 9 сарын гүйцэтгэлийн мэдээ

ТӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны жилийн 2013 ОНЫ 9 САР		ХУВЬ		ЗӨРҮҮ		
	өн үеий	Төлөв.	Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 - 2)	(4 - 3)
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН Д	4,043.7	7,442.7	5,208.3	4,067.6	78.1	54.7	-1,140.6
УРСГАЛ ЗАРДАЛ	3,088.4	4,904.2	3,659.3	3,166.9	86.5	64.6	-492.5
Бараа, үйлчилгээний зардал	1,387.0	2,479.6	1,919.4	1,639.4	85.4	66.1	-280.0
Цалин хөлс	836.0	1,408.6	1,065.0	1,018.1	95.6	72.3	-46.9
Нийгмийн даатгалын шимтгэл	77.1	133.1	101.6	94.4	92.9	70.9	-7.2
Бараа, үйлчилгээний бусад зардал	550.9	1,071.1	854.4	621.3	72.7	58.0	-233.1
Зээлийн үйлчилгээний төлбөр	91.5	397.8	239.2	138.9	58.1	34.9	-100.3
Татаас ба шилжүүлэг	1,610.0	2,026.8	1,500.7	1,388.5	92.5	68.5	-112.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	910.3	2,488.9	1,485.5	798.1	53.7	32.1	-687.4
Дотоод эх үүсвэрээр:	876.2	2,119.2	1,320.4	588.3	44.6	27.8	-732.1
Гадаад эх үүсвэрээр	34.0	369.7	165.1	209.8	127.1	56.8	44.7
ЭРГЭЖ ТӨЛӨГ ДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	45.0	49.6	63.4	102.7	161.9	207.0	39.3
УРСГАЛ ТЭНЦЭЛ	362.3	2,181.4	497.4	769.2	154.7	35.3	271.9
НИЙТ ТЭНЦЭЛ	-556.9	-356.3	-1,049.5	-130.9	12.5	36.7	918.6

Эхний 9 сарын гүйцэтгэлээр нийт урсгал зардал 86.5 хувьтай байгаа нь төлөвлөсөн хэмжээнээс 492.5 тэрбум төгрөгөөр бага байна. Үүнээс улсын төсөв 84.7 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөснөөс 439.3 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсөв 86.3 хувь буюу төлөвлөснөөс 149.8 тэрбум төгрөгөөр, Хүний хөгжил сангийн 98.5 хувьтай буюу төлөвлөснөөс 3.1 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сан 98.3 хувьтай буюу төлөвлөснөөс 13.3 тэрбум төгрөгөөр тус тус бага зарцуулагдсан гүйцэтгэлтэй байна.

Нэгдсэн төсвийн 2013 оны эхний 9 сарын урсгал зардлын гүйцэтгэл нь жилийн батлагдсан төлөвлөгөөний 54.7 хувьтай тэнцүү байна. Зарлагын гүйцэтгэл бага хувьтай гарахад санхүүжүүлэх эх үүсвэр дутагдалтай байгаа нь нөлөөлж байна.

Төсвийн урсгал зардлын 2013 оны тодотголын санал

Монгол Улсын 2013 оны төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлтэй уялдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу төсвийн алдагдлын хэмжээг ДНБ-ний 2.0 хувиас хэтрүүлэхгүй байх зорилгоор төсвийн зарлагыг нийт **814.8** тэрбум төгрөгөөр бууруулах, үүнээс урсгал зардлыг **234.2** тэрбум төгрөгөөр батлагдсан түвшингээс бууруулан тооцлоо.

Дараах зарчмыг үндэслэн урсгал зардлыг бууруулах тодотголын саналыг боловсрууллаа.
Үүнд:

1. 2013 оны эхний 8 сард хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс хэмнэгдсэн урсгал зардлыг олгохгүй байх;
2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2013 оны 10 дугаар сараас он дуусах хүртэлх хугацаанд зарцуулахаар төлөвлөсөн тэвчиж болох урсгал зардлыг бууруулах, өмнөх саруудад ашиглагдаагүй зардлыг хэмнэх;
3. Төсвийн санхүүжилтийг бууруулснаар өр, авлага үүсгэхгүй, төсвийн сахилга батыг хатуу сахих, зардал хэмнэх боломжийг дайчлах;
4. Зардлыг санхүүжүүлэхдээ төсвийн орлогын эх үүсвэртэй уялдуулан үе шаттай санхүүжүүлэх;

Дээрх зарчмын дагуу холбогдох тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагч нараас тодотголын төсөлд ирүүлсэн саналыг харгалзан тэргүүлэх ач холбогдолтой, үйл ажиллагаа нь эхэлсэн бөгөөд 2013 онд багтаан зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай зарим арга хэмжээг бууруулахгүй байхаар авч үзвэл нэгдсэн төсвийн нийт урсгал зардал **234.2** тэрбум төгрөгөөр анхны батлагдсан түвшингээс буурахаар байна. Төсвийн тодотголоор урсгал зардлыг бууруулах дараах арга хэмжээ, зардлууд байна. Үүнд:

- Бүх шатны төсөвт байгууллагуудын тэвчиж болох урсгал зардлыг 101.2 тэрбум төгрөгөөр бууруулах;
- Зээлийн үйлчилгээний төлбөрийг 2013 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн 47.5 тэрбум төгрөгөөр бууруулах;
- Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан зарим арга хэмжээний урсгал зардалд төлөвлөсөн зардлыг 25.0 тэрбум төгрөгөөр бууруулах;
- Эрсдлийн санд төлөвлөсөн 5.0 тэрбум төгрөгийг бууруулах;

- ҮХААС-ын төсвийн багцад батлагдсан махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжид олгодог урамшууллын зардлын хэмнэлтийг буюу 4.0 тэрбум төгрөгөөр бууруулах;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр төлөвлөсөн Эрүүл мэндийн төвлөрсөн арга хэмжээний зардлыг 5.1 тэрбум төгрөгөөр бууруулах;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбоотой 2013 онд төлөвлөгдсөн урсгал зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 5.0 тэрбум төгрөгийг хэмнэх;
- Халамжийн сангаас олгож буй зарим нэр, төрлийн халамжийн зардлыг хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн 2.0 тэрбум төгрөгөөр бууруулах;
- НДС-д төлөх өглөгийг хугацааг хойшлуулах. Улсын төсвөөс нийгмийн даатгалын санд төлөх өглөгийг барагдуулахаар 2013 онд төлөвлөсөн дүнг бууруулж, төлбөр хийх хугацааг 2014 онд хойшлуулах;
- Хүний хөгжил сангийн зардлын хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн нийт зардлын хэмжээг 10.0 тэрбум төгрөгөөр бууруулж хүүгийн төлбөрт 8.6 тэрбум төгрөг тусгах;
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд Төсвийн тухай хууль тогтоомжийн дагуу төвлөрөх орлогын биелэлт, хүлээгдэж буй гүйцэтгэл буурч байгаатай холбогдуулан тус сангаас орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх орлогын шилжүүлгийг 38.0 тэрбум төгрөгөөр бууруулах.

Ингэснээр 2013 оны нэгдсэн төсвийн урсгал зардлыг нийт 234.2 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцов.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн тодотголын талаар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багц

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 3,629.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 11,434.3 сая төгрөг батлагдсаныг 656.5 сая төгрөгөөр бууруулж, 10,777.9 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн багц

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 7,755.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 17,625.7 сая төгрөг батлагдсаныг 1,658.8 сая төгрөгөөр бууруулж, 15,966.9 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн багц

Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн багцын урсгал зардлыг 2013 онд нийт 554.9 сая төгрөг батлагдсанаас бараа үйлчилгээний бусад зардлыг 18.7 сая төгрөгөөр, татаас ба урсгал шилжүүлгийг 2.4 сая төгрөгөөр нийт 21.1 сая төгрөгөөр бууруулан тус даргын төсвийн багцыг 533.8 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багц

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардал 2013 онд 38,809.1 сая төгрөг батлагдсанаас 1,046.0 сая төгрөгөөр бууруулж 37,763.1 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн даргын төсвийн багц

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардал 2013 онд 1,594.2 сая төгрөг батлагдсанаас бараа үйлчилгээний зардлыг 77.7 сая төгрөгөөр бууруулж 1,516.5 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Авилгатай тэмцэх газрын даргын төсвийн багц

Авилгатай тэмцэх газрын даргын төсвийн багцын урсгал зардал 2013 онд 8,327.8 сая төгрөг батлагдсанаас 46.2 сая төгрөгөөр бууруулж 8,281.6 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багц

Үндэсний Статистикийн хорооны даргын төсвийн багцын урсгал зардал 2013 онд 8,839.8 сая төгрөг батлагдсанаас 155.3 сая төгрөгөөр бууруулж, 8,684.5 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа. Үүнээс: Бараа үйлчилгээний бусад зардлыг 124.7 сая төгрөгөөр, татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг 3.5 сая төгрөгөөр тус тус бууруулан 2013 оны төсвийн тодотголд тусгалаа.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багц

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын урсгал зардал 2013 оны 8 дугаар сарын байдлаар нийт 1,579.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 1,113.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багцын урсгал зардалд 2013 онд 2,304.3 сая төгрөг батлагдсанаас бараа үйлчилгээний бусад зардлаас 102.1 сая төгрөгөөр бууруулж 2,202.1 сая төгрөгөөр 2013 оны төсвийн тодотголд тусгалаа.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын даргын төсвийн багц

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын даргын төсвийн багцын урсгал зардал 2013 оны 8 дугаар сарын байдлаар 576.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 192.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын даргын төсвийн багцын урсгал зардалд 2013 онд 920.2 сая төгрөг батлагдсанаас 22.9 сая төгрөгөөр бууруулж, 897.2 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Үндэсний ерөнхий аудиторовын төсвийн багц

Үндэсний ерөнхий аудиторовын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 1,158.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үндэсний ерөнхий аудиторовын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 1,633.7 сая төгрөг батлагдсаныг 53.6 сая төгрөгөөр бууруулж, 1,580.1 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн багц

Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 345.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 665.1 сая төгрөг батлагдсаныг 36.8 сая төгрөгөөр бууруулж, 628.2 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багц

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 11,565.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 17,900.9 сая төгрөг батлагдсанаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах зардлын хэмнэлт 5,028.8 сая төгрөгийг бууруулж, 12,872.1 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багц

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 21,254.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 71,895.9 сая төгрөг батлагдсанаас Засгийн газрын шинэ бодлогын нөөц хөрөнгө 25,000.0 сая төгрөг болон харьяа байгууллагуудын тэвчиж болох урсгал зардал 1,066.3 сая төгрөг, нийт 26,066.3 сая төгрөгийг төсвийн тодотголоор бууруулахаар тооцлоо. Харин “Монгол Улсад Цөмийн оношилгоог хөгжүүлэх, сайжруулах СПЕКТ/СТ аппарат нэвтрүүлэх” төслийн хүрээнд оруулах 2 хэмжээст компьютер томографийн аппаратыг 3 хэмжээст компьютер томографийн аппарат болгон сайжруулахад шаардагдах 300.0 мянган еврогийн зардал болон дозиметрийн лабораторийг засварлахад шаардагдах 81.0 сая төгрөг, нийт 750.0 сая төгрөгийг төсвийн тодотголд нэмэгдүүлж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны тодотгосон төсвийг 46,579.6 сая төгрөгөөр төлөвлөлөө.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багц

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 8,944.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 15,821.1 сая төгрөг батлагдсаныг 652.2 сая төгрөгөөр бууруулж, 15,168.8 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багц

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багц нийт зардал 2013 оны 8 дугаар сарын байдлаар урсгал 50,853.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцын 2013 оны урсгал зардал 85,987.4 сая төгрөг батлагдсанаас 2,591.8 сая төгрөгөөр бууруулж 83,395.6 сая төгрөгөөр 2013 оны төсвийн тодотголд тусгалаа. Үүнээс: Бараа үйлчилгээний бусад зардлыг 1,229.6 сая төгрөгөөр, татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг 188.7 сая төгрөгөөр бууруулсанаас “Дотоодын Их сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 87 дугаар тогтоолын дагуу Онцгой байдлын Ерөнхий газрын Сургалтын төвийн 2013 оны төсөв болох 236.1 сая

төгрөгийг Монгол Улсын Шадар сайдын 2013 оны төсвөөс хасаж Хууль зүйн сайдын багцын төсөвт шилжүүлэн 2013 оны төсвийн тодотголд тусгалаа.

Сангийн сайдын төсвийн багц

Сангийн сайдын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын 394,843.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Сангийн сайдын төсвийн багц дахь зээлийн үйлчилгээний төлбөрийг 47.5 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцлоо.

Улсын Их Хурлын “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2013 оны 6 дугаар тогтоолын 3 дугаарт заасны дагуу сангийн эх үүсвэрт Засгийн газраас олгох 50 тэрбум төгрөгийг Сангийн сайдын батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэхээр тооцлоо.

Ингэснээр Сангийн сайдын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 961,947.9 сая төгрөг батлагдсаныг 115,564.6 сая төгрөгөөр бууруулж, 846,383.2 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Гадаад харилцааны сайдын төсвийн багц

Гадаад харилцааны сайдын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 29,684.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Гадаад харилцааны сайдын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 42,774.2 сая төгрөг батлагдсаныг 1,316.1 сая төгрөгөөр бууруулж, 41,458.1 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Хууль зүйн сайдын төсвийн багц

Хууль зүйн сайдын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын 201,060.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хууль зүйн сайдын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 335,123.8 сая төгрөг батлагдсанаас цалин хөлс НДШ-ийн зардлыг 2,458.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,527.2 сая төгрөгөөр, татаас шилжүүлгийн зардлыг 2,220.2 сая төгрөгөөр нийт 10,206.6 сая төгрөгөөр бууруулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа ангиудын туслах үйл ажиллагааны орлого болон зарлагыг 2,215.6 сая төгрөгөөр, Цагдаагийн гэрээт хамгаалалт, сүүж уулын сувиллын газрын орлого зарлагыг 3,280.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж нийт урсгал зардлыг 330,649.7 сая төгрөг байхаар төсвийн тодотголд тусгалаа. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 87 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Үадар сайдын төсвийн багц дахь Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Тусгай мэргэжлийн сургалтын төвийн орон тоо урсгал зардлыг Хууль сахиулахын их сургуульд шилжүүлэн тусгалаа.

Батлан хамгаалах сайдын төсвийн багц

Батлан хамгаалах сайдын төсвийн багцын урсгал зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар 96,024.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Батлан хамгаалах сайдын төсвийн багцын 2013 оны урсгал зардалд нийт 151,181.7 сая төгрөг батлагдсанаас орон тооны нөхөн хангалт дутуу хийгдсэнээс хэмнэгдэж байгаа цалин хөлс НДШ-

ийн зардлыг 5,951.6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад болон татаас шилжүүлгийн зардлыг 252.0 сая төгрөгөөр нийт 6,203.6 сая төгрөгөөр бууруулж урсгал зардлыг 144,978.1 сая төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багц

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны улсын төсвөөс санхүүжих урсгал зардал 873,143.3 сая төгрөгөөр батлагдсаныг 2013 оны төсвийн тодотголын төслөөр 874,303.6 сая төгрөг болгон 1,160.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж тооцлоо.

2013 оны 8 сарын мэдээнд үндэслэн төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж 1,000.0 сая төгрөг, үндэсний тэтгэлэг 1,000.0 сая төгрөг, бусад урсгал зардал 1,050.1 сая төгрөгийг тус тус бууруулж тооцлоо. Мөн сургууль, цэцэрлэгийн хэмнэгдэж буй урсгал зардлыг зарим дутагдаж буй зайлшгүй шаардлагатай зардалд шилжүүлэх, түүнчлэн аймаг хооронд холбогдох зохицуулалтыг хийлээ.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор оюутны нийтийн тээврийн сэлгэн зорчих коэффициентийг 1.45 болгож нэмэгдүүлсний улмаас 2013 онд зайлшгүй нэмж шаардагдах 6,872.0 сая төгрөгийг 2013 оны төсөвт нэмэгдүүлэн 28,837.6 сая төгрөг байхаар тооцлоо.

Эрүүл мэндийн сайдын төсвийн багц

Эрүүл мэндийн сайдын багцын 2013 оны эхний 8 сарын гүйцэтгэлийн үзүүлэлтээр урсгал зардал 249.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны урсгал төсвийн зардал нийт 413.8 тэрбум төгрөгөөр батлагдсаныг 2013 оны төсвийн тодотголын төслөөр 402.9 тэрбум төгрөг болгох буюу нийт 10.8 тэрбум төгрөгөөр бууруулахаар тооцлоо. Бууруулахаар тооцсон урсгал зардалд хэмнэгдэж байгаа буюу тэвчиж болох төсвийн байгууллагуудын урсгал үйл ажиллагааны зардал 3 тэрбум төгрөг, хэрэгжих боломжгүй болон хойшлогдож байгаа төсөл, хөтөлбөрүүд болох Эрүүл хүүхэд аяны 5.0 тэрбум төгрөг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааг сайжруулах төслийн үйл ажиллагааны зардлыг зардлаас 1.6 тэрбум төгрөгөөр, Баруун бүсийн эмчилгээ, оношлогооны төвийг сайжруулах төслийн зардлын 0.4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулахаар тооцсон болно.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны сайдын багцын урсгал зардал 2013 оны 8 дугаар сарын байдлаар 287.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг 2013 онд нийт 387.6 тэрбум төгрөг батлагдсанаас 27.8 тэрбум төгрөгөөр бууруулж, 359.8 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа. Үүнээс Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаасыг 25.7 тэрбум төгрөгөөр, алдарт эхийн одонтой эхчүүдийн тэтгэмжийн зардал үлдэгдэлтэй байгаа тул 2.1 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан 2013 оны төсвийн тодотголд тусгалаа.

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багц

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2013 оны урсгал зардал 80287.3 сая төгрөгөөр батлагдсаныг 2013 оны төсвийн тодотголын төслөөр 79026.3 ая төгрөг болгон 1261.0 сая төгрөгөөр буурч тооцогдлоо.

2013 оны 8 сарын мэдээгээр Соёл, урлагийг хөгжүүлэх зардлын төлөвлөгөө 4.7 тэрбум төгрөг байснаас гүйцэтгэлээр 2.5 тэрбум төгрөг гарч нийт 2.2 тэрбум төгрөгийн санхүүжилт дутуу хийгдсэн байна. Иймд уг зардлаас 700 сая төгрөгийг бууруулж тооцлоо. Мөн 561.0 сая төгрөгийн бусад урсгал зардлыг бууруулж тооцлоо.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багц

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын багцын 2013 оны эхний 8 сарын урсгал зардал 34.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан үзүүлэлттэй байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны урсгал зардал нийт 68.1 тэрбум төгрөг батлагдсанаас 1.9 тэрбум төгрөгөөр бууруулж, 2013 оны тодотгосон төсвийг 66.1 тэрбум төгрөгөөр тооцлоо. Үүнд төсвийн байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлаас 0.3 тэрбум төгрөг, Байгаль хамгаалах сангаас 0.4 тэрбум төгрөг, Цэвэр агаар сангийн зардлыг 1.2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулахаар тооцлоо.

Хөдөлмөрийн сайдын төсвийн багц

Хөдөлмөрийн сайдын багцын урсгал зардалд 2013 оны эхний 8 сард 84.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын төсвийн орлого бүрдэлтийн нөхцөл байдалтай уялдуулж, Хөдөлмөрийн сайдын төсвийн багцын урсгал зардлыг батлагдсан дүнгээс 6.5 тэрбумаар бууруулж, 142.6 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа. Үүнээс суралцагсдад олгох амьжиргааны тэтгэлэгийг гүйцэтгэлтэй уялдуулж, 2.5 тэрбумаар, төвлөрсөн арга хэмжээний зардалд тусгагдсан дотоодын сургалт семинар, ном товхимол г.м зардлуудыг 1.9 тэрбумаар, шуудан холбоо, гадаад томилолт, урсгал засвар болон бусад тогтмол шинжтэй урсгал зардлыг 2.1 тэрбумаар бууруулж, тус тус төсвийн тодотголд тусгалаа.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багц

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын багцын урсгал зардалд 2013 оны эхний 8 сард гүйцэтгэлээр 40.0 тэрбум төгрөг зарцуулагдсан байна. Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын урсгал зардлыг батлагдсан дүнгээс 4.9 тэрбумаар бууруулж, 104.2 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгалаа.

Барилга, хот байгуулалтын сайдын төсвийн багц

Барилга, хот байгуулалтын сайдын 2013 оны урсгал зардал 16,195.2 сая төгрөгөөр батлагдсаныг 2013 оны төсвийн тодотголын төслөөр 14,391.0 сая төгрөг болгон 1,804.2 сая төгрөгөөр бууруулж тооцлоо. 2013 оны 8 сарын мэдээнд үндэслэн төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 942.4 сая төгрөг, газрын зургийн зардлыг 300.0 сая төгрөг, газрын

хянан баталгааны зардлыг 250.0 сая төгрөг, бусад урсгал зардал 311.8 сая төгрөгийг тус тус бууруулж тооцлоо.

Зам, тээврийн сайдын төсвийн багц

2013 оны 8 сарын мэдээнд үндэслэн Зам, тээврийн сайдын 2013 оны урсгал зардал 26,827.5 сая төгрөгөөр батлагдсаныг 2013 оны төсвийн тодотголын төслөөр 24,581.9 сая төгрөг болгон 2,245.6 сая төгрөгөөр буурч тооцлоо.

Уул уурхайн сайдын төсвийн багц

Уул уурхайн сайдын 2013 оны урсгал зардал 11,001.0 сая төгрөгөөр батлагдсаныг 2013 оны төсвийн тодотголын төслөөр 10,191.3 сая төгрөг болгон 809.7 сая төгрөгөөр бууруулж тооцлоо. 2013 оны 8 сарын мэдээнд үндэслэн төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 385.0 сая төгрөг бусад урсгал зардал 424.7 сая төгрөгийг тус тус бууруулж тооцлоо.

Эрчим хүчний сайдын төсвийн багц

Эрчим хүчний сайдын 2013 оны урсгал зардал 40,318.1 сая төгрөгөөр батлагдсаныг 2013 оны төсвийн тодотголын төслөөр 39,978.1 сая төгрөг болгон 340.0 сая төгрөгөөр бууруулж тооцлоо. 2013 оны 8 сарын мэдээгээр Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын төлөвлөгөө 217.1 сая төгрөг байснаас гүйцэтгэлээр 36.9 сая төгрөг гарч нийт 180.0 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Эдийн засгийн хөгжлийн сайдын төсвийн багц

Эдийн засгийн хөгжлийн сайдын төсвийн багцын урсгал зардал 2013 оны 8 дугаар сарын байдлаар 3,058.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Эдийн засгийн хөгжлийн сайдын төсвийн багцын урсгал зардлыг 2013 онд 9,126.8 сая төгрөг батлагдсанаас бараа үйлчилгээний бусад зардлыг 259.4 сая төгрөгөөр бууруулж 8,867.4 сая төгрөгөөр 2013 оны төсвийн тодотголд тусгалаа.

3.3. Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуулиар сангийн орлогыг 875.3 тэрбум төгрөгөөр батласныг 96.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 971.5 тэрбум төгрөгөөр, сангийн зарлагыг 1,066.8 тэрбум төгрөгөөр батласныг 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1,067.8 тэрбум төгрөгөөр, улсын төсвөөс олгох санхүүжилтийг 294.3 тэрбум төгрөгөөр батласныг 268.6 тэрбум төгрөгөөр тус тус төсвийн тодотголд тусгаж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого 96.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа нь:

“Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийн хүрээнд 1995 - 2000 оны хооронд нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй буюу төлөх боломжгүй байсан иргэний даатгуулагч өөрөө төлөх 10 хувийг тухайн онуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлсөнөөс нийгмийн даатгалын санд 31.1 тэрбум төгрөгийн орлого орсон байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2013 оны 07 тоот тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс нэг цагт 1142 төгрөг 85 мөнгө байхаар тогтоосны дагуу нийгмийн даатгалын сангийн орлогын аж ахуйн нэгж байгууллагаас төлөх шимтгэл, сайн дурын даатгуулагчийн шимтгэлийг 65.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж тооцсон.

Нийгмийн даатгалын хамрах хүрээ өргөжин 2,089 ажил олгогч, 15,934 даатгуулагч шинээр хамрагдсан байна.

Аймаг, нийслэл дүүргийн нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын 2013 оны төсвийн гүйцэтгэл, нийгмийн даатгалын байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн сангийн зарлагыг 1.0 тэрбум нэмэгдүүлж тооцов.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик мэдээнээс үзэхэд аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2011 онд 424,400 төгрөг байсан бол 2012 онд 557,600 төгрөг, 2013 оны 1-р улиралд 692,300 төгрөгт хүрэн өссөн байна. Ийнхүү дундаж цалингийн өсөлт, хүүхэд төрүүлж буй эхчүүдийн тооны өсөлт, нийгмийн даатгалд хамрагдаж буй иргэдийн өсөлтөөс хамаарч жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 3.1 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн тэтгэмжийг 2.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж буй Эрүүл Монгол хүүхэд аяны зардал 5.1 тэрбум төгрөгөөр буурч байгаатай холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангийн зардал мөн төдий хэмжээгээр буурч байна. Түүнчлэн рашаан сувиллын зардлаас 1.0 тэрбум төгрөг хэмнэгдэж байгаа бөгөөд эмийн үнийн хөнгөлөлтийн зардал 1.0 тэрбум төгрөгөөр өсч байна.

3.4. Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн орлого тодотгосон төлөвлөгөөгөөр 1,776.8 тэрбум төгрөг, зарлага нь 1,796.5 тэрбум төгрөгөөр тооцогдлоо. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бууралтад дараах хүчин зүйл гол нөлөөлсөн байна. Үүнд:

- Монгол улсын 2013 оны төсвийн тухай хуулиар орон нутагт 152.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгогдохоор төлөвлөгдсөн нь төсвийн тодотголоор 154.8 тэрбум төгрөг болж 2.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна. Энэхүү өсөлтөд санхүүгийн дэмжлэг авдаг аймгуудын орлого өндөр дүнгээр тасарсан нь гол нөлөөлсөн. Тухайлбал, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварын 2013 оны орлого тасарч байгаатай холбогдуулан төсвийн тодотголоор аймгуудын орлогын төлөвлөгөөг 2.9 тэрбум төгрөгөөр бууруулж байна. Мөн ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 12.5 тэрбум төгрөгөөр бууруулан тооцлоо.
- Орон нутгийн төсвийн суурь зарлага 5,216.0 сая төгрөгөөр буурсан. Тухайлбал, Архангай, Говь-Алтай, Дундговь, Завхан, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл, Дархан–Уул аймгуудын нийгмийн халамжийн сангийн зардал 2013 оны эхний 8 сарын байдлаар хэмнэлттэй байгаа тул орон нутгийн халамжийн суурь зардлыг нийт 5,456.0 сая төгрөгөөр бууруулсан бол Булган аймагт дутагдаж буй ахмад настны хөнгөлөлтийн дэмжлэгийн зардалд 240.0 сая төгрөг нэмж тусгалаа.

- Төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын урсгал зарлагыг 2,662.4 сая төгрөгөөр хэмнэхээр тооцсон.
- Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн зарлага 38.0 тэрбум төгрөгөөр 2013 оны төлөвлөгөөнөөс буурахаар тооцогдлоо.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн талаар: Нэгдсэн төсвийн 2013 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг бүрдүүлж байгаа төсвийн орлого буурахтай холбоотойгоор орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг дундажаар 1.5 тэрбум төгрөгөөр, нийслэлийн хөгжлийн санд олгох дүн 6.5 тэрбум төгрөгөөр тус тус буурахаар тооцогдлоо.

Улсын төсөвт дотоодын бараа, ажил үйлчилгээний НӨАТ-ын орлогоос 2013 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэнд санд шилжүүлэх дүн 27.5 тэрбум төгрөгөөр буурч байна. Харин орон нутгийн суурь төсвийн тэнцлийн ашгаас суурь зардалтай тэнцэх хэмжээний хэсгийг тухайн шатны төсөвт нь үлдээн, давсан ашгийг ОНХНСанд төвлөрүүлэхээр хуульчилсны дагуу Улаанбаатар, Өмнөговь болон Орхон аймгуудаас төвлөрөх орлогыг 24.2 тэрбум төгрөг болгон бууруулж, аймаг, нийслэлд хуваарилахаар тооцлоо. Хандив тусламжийн орлого байхгүй ба дээрх эх үүсвэрээс бүрдсэн нийт 186.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг хүн ам, газар нутаг, татварын идэвх, орон нутгийн хөгжлийн индексийн итгэлцүүрүүдэд харгалзуулан хуваарилсан. Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болох Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь болох 28.3 тэрбум төгрөгийг 4.8 тэрбум төгрөгөөр бууруулж хүн амд хамааруулан шилжүүлэхээр байна.

3.5. Хөрөнгө оруулалт

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар нийт 1,550.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 10 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар 473.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 30.5 хувьтай байна.

УИХ-ын 2011 оны 57 дугаар тогтоолоор 4 дүгээр сарын 1 гэхэд хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дүгнэж, гэрээ байгуулсан байхыг даалгасан боловч 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 399.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тендер зарлагдаагүй, гэрээ байгуулагдаагүй, ажил нь эхлээгүй байгаа юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсөв нь бэлэн болоогүй төсөл, арга хэмжээ тусгагдсанаас тэдгээрийн зураг төслийг боловсруулах, магадлал хийлгэхэд цаг хугацаа ихээхэн зарцуулж, улмаар гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагаа оройтдог, түүнчлэн Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн “Барилгын дүрмүүд батлах тухай” 18 тоот тушаал, Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн “Барилгын норм ба дүрэм батлах тухай” 181 тоот тушаалаар барилга угсралтын ажлын машин механизмын болон тээврийн зардал, хөдөлмөр зарцуулалтын жишиг норм тус тус өссөнөөс барилгын төсөвт өртөг нэмэгдэж, улмаар барилгын магадлал хийгдсэн төсөвт өртөг нь хуулиар батлагдсан төсөвт өртгөөс хэтэрсэнээс гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах боломжгүй болсон байдал түгээмэл болжээ.

Барилга угсралтын ажлыг технологийн горим, стандартын дагуу гүйцэтгэх шаардлага, одоо эхэлж байгаа барилгын ажлыг төсвийн жилдээ багтаан чанартай барьж дуусгах боломж үндсэндээ хязгаарлагдсан зэргийг харгалзан оройтож гэрээ байгуулагдсан хөрөнгө оруулалтын ажилд төсөвлөгдсөн хөрөнгийг ашиглах боломжгүй болсон гэж үзлээ.

Түүнчлэн, газрын асуудал эцэслэн шийдэгдээгүй, техникийн нөхцөл бүрдээгүй, тендер шалгаруулалт оройтсон, зураг төсөвт өөрчлөлт орсон болон гүйцэтгэгч байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан гэрээ байгуулагдаж ажил нь эхэлсэн боловч ажлын явц удаашралтай байгаа зарим барилга байгууламжид төсөвлөгдсөн хөрөнгийг бүрэн зарцуулж чадахгүйд хүрч байна.

Иймд 2013 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүнг нийт дүнгээр 425.8 тэрбум төгрөгөөр бууруулж, тодотгосон төлөвлөгөөг танилцуулж байна.

Хэдийгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хэмжээг ийнхүү анх төлөвлөснөөс 30 шахам хувиар бууруулж байгаа боловч эдийн засгийн өсөлтийг дэмжих, дотоодын аж ахуйн нэгжүүдийн чадавхи, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, шинээр бий болгох, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бусад эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримталж байна. Тухайлбал, энэ 2013 онд Хөгжлийн банк болон Чингис бондын хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтыг өнгөрсөн оныхоос 3 дахин нэмэгдүүлж 1.5 орчим их наяд, 2014 онд 2.4 орчим их наяд төгрөгт хүргэхээр тооцож байна.

3.6. Хүний Хөгжил сан

ХХС-гийн 2013 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл

Орлого: Хүний хөгжил санд оны эхний 9 сард ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр нийт 284.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрөхөөр тооцсоноос 197.8 тэрбум төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө эхний 9 сарын байдлаар 86.7 тэрбум төгрөгөөр тасарч байна.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр тус санд төвлөрөх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 67.2 тэрбум төгрөгөөр тасарч, Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулсанаар төвлөрөхөөр тооцсон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн орлого 154.9 тэрбум төгрөг төсөвт төвлөрөхөөргүй байна. Мөн тус санд 70.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлого орохоор тооцсон нь хүлээгдэж буй гүйцэтгэлээр 68.3 тэрбум төгрөг болж Хүний хөгжил сангийн 2013 оны тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө нийтдээ 223.8 тэрбум төгрөгөөр бага гарахаар байна.

Зарлага, өр төлбөр: Хүний хөгжил сангаас оны эхний 9 сард нийт 214.7 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийхээс 204.1 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийлээ. Эхний 9 сард тус сангийн төсвөөс иргэдэд өмнөх онуудад аваагүй хишиг, хувийг нөхөж олгоход 32.0 тэрбум төгрөг зарцуулахаас 27.4 тэрбум төгрөг, хүүхдийн мөнгөнд 173.6 тэрбум төгрөг зарцуулахаас 168.6 тэрбум төгрөг зарцуулагдаж төсвийн зарлага эхний 9 сарын байдлаар зарлага 9.6 тэрбум төгрөгөөр хэмнэгдэж байна.

Эхний 9 сард Эрдэнэс Тавантолгой ХК-ийн өмнөх онуудад төвлөрүүлсэн урьдчилгаа төлбөрт 3.7 тэрбум төгрөгийг татварын орлогод суутган тооцлоо. Мөн 2013 оны 10 дугаар сарын эхэнд тус компанийн төлөх татвар, төлбөрөөс нэмж 5.8 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөрийн өглөгт суутган тооцож, нийт суутган тооцсон хэмжээ 9.5 тэрбум төгрөг боллоо.

Тэнцэл, мөнгөн хөрөнгийн өөрчлөлт: Хүний хөгжил сангаас үлдэж буй саруудад Эрдэнэс МГЛ компанитай байгуулсан урьдчилгаа төлбөрийн гэрээний дагуу нэмж 52.9 тэрбум төгрөгийг урьдчилгаа төлбөрт суутган тооцохоор байгаа бөгөөд 2012 оны төсвийн алдагдалыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын бондын гэрээний дагуу 108.1 тэрбум төгрөгийн бондын төлбөрийг барагдуулна. Өөрөөр хэлбэл хүний хөгжил сангаас 2013 онд нийт 170.5 тэрбум төгрөгийн өр, төлбөрийг төлж барагдуулах шаардлагатай байгаа ба тус сангийн 2013 оны орлогын хэмжээ сангийн зарлага болон өр, төлбөрийг санхүүжүүлж хүрэлцэхээргүй байна. Хүний хөгжил сангаас 2013 онд нийт 282.8 тэрбум төгрөгийн урсгал зарлагыг санхүүжүүлж, өмнөх 2010-2012 онуудын төсөвт авсан урьдчилгаа төлбөр болон Засгийн газрын бондын төлбөрт нийт 170.5 тэрбум төгрөгийг төлж барагдуулахад 453.3 тэрбум төгрөг шаардлагатай байна. Үүний 397.6 тэрбум төгрөгийг төсвийн орлогоор санхүүжүүлж үлдэх 55.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Засгийн газрын бонд гарган бүрдүүлэхээр УИХ-ын тогтоолын төслийг боловсрууллаа.

Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлт, шийдвэрлэх асуудлууд: ХХС-гийн 2013 оны төсвийн гүйцэтгэлийг хангахад дараах асуудлуудыг төсөвт тодотгол хийх замаар шийдвэрлэхээр хууль, тогтоолын төсөлд тусгалаа. Үүнд:

1. Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн алдагдалыг санхүүжүүлэх зорилгоор нийт 313.1 тэрбум төгрөгийн бонд гаргах зөвшөөрөл олгох тухай УИХ-ын тогтоол 64 дүгээр тогтоол 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр буюу Хүний хөгжил сангийн 2013 оны төсөв батлагдсаны дараа гарсан тул Нийгмийн даатгалын ерөнхий газрын худалдаж авсан 108.1 тэрбум төгрөгийн бондын хүүгийн төлбөр 8.6 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангийн 2013 оны төсөвт нэмж тусгалаа.
2. Хүний хөгжил сангийн 2013 оны төсөвт Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулсанаар өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрөөр орохоор тооцсон 154.0 тэрбум төгрөгийн орлого бүхэлдээ тасрахаар байгаа;
3. Тус санд төвлөрөх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 67.2 тэрбум төгрөгөөр тасрахаар байгаа;

Дээрх асуудлуудыг шийдвэрлэх үүднээс Хүний хөгжил сангийн 2013 оны төсөвт дараах өөрчлөлтийг хийхээр “Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл болон дагалдах УИХ-ын шийдвэрийн төслүүдэд тусгасан. Үүнд:

1. Хүний хөгжил санд төвлөрөх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг нийт 222.1 тэрбум төгрөгөөр, ногдол ашгийн орлогыг 1.7 тэрбум төгрөгөөр тус тус бууруулах;
2. Эхний найман сарын гүйцэтгэлд үндэслэн Хүний хөгжил сангаас иргэдэд олгох бэлэн мөнгийг 10.0 тэрбум төгрөгөөр бууруулах;
3. Засгийн газрын бондын үндсэн төлбөрийг гэрээнд заасныг баримтлан 84.0 тэрбум төгрөгөөр бууруулах;

4. Тус сангийн 2012 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын бондын хүүгийн зардал 8,648.0 сая төгрөгийг төсөвт нэмэх;
5. Тус сангийн 2013 оны төсөвт дутагдаж буй эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 55.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын бонд гаргах зөвшөөрөл олгох асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх;

3.7. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр

Гадаад зээлийн үндсэн төлбөр: 2013 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр гадаад зээлийн үндсэн төлбөрт 56.3 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд 9-12 дугаар сард хүлээгдэж буй гүйцэтгэл 42.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарахаар хүлээгдэж байна. Хүлээгдэж буй гүйцэтгэл дээр үндэслэсэн тооцоо нь гадаад зээлийн үндсэн төлбөрийн төлөвлөгөөт дүнг 10.9 тэрбум төгрөгөөр давахаар байгаа юм. Иймд гадаад зээлийн үндсэн төлбөрт нийт 87.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн бөгөөд дүнгийн хувьд 98.4 тэрбум төгрөг болгон 10.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон төсөвт тусгалаа. Гадаад валютын ханшны өөрчлөлтийн нөлөөлөл, Болгар улсад төлөх зээлийн өр 1.4 тэрбум төгрөгийн төлбөрийг нэмж оруулсан, мөн гадаад валютын ханш өссөнөөр нийт гадаад зээлийн төлбөр 10.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа юм.

Гадаад зээлийн хүүгийн төлбөр: Гадаад зээлийн хүүгийн төлбөрт 8 дугаар сарын гүйцэтгэлээр 21.7 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд 9-12 дугаар саруудад 11.3 төгрөгөөр нэмэгдүүлэхээр байна. Иймд 2013 онд гадаад зээлийн хүүгийн төлбөрт төлөхөөр төлөвлөсөн 27.5 тэрбум төгрөг гүйцэтгэлээр 33.0 тэрбум төгрөг болж өмнө төлөвлөсөн дүнгээс 5.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Энэхүү өөрчлөлтөд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь гадаад валютын төгрөгтэй харьцах ханшны өөрчлөлт төлөвлөж байсан хэмжээнээс нэмэгдсэн нь гол нөлөөллийг үзүүлж байна.

Гадаад зээлийн ашиглалт: 2013 оны 8 дугаар сарын гүйцэтгэлээр гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн гүйцэтгэл 202.4 тэрбум төгрөг байна. Үлээгдэж буй гүйцэтгэл нийт 330.1 тэрбум төгрөг байхаар тооцоологдож байна. Энэ нь гадаад зээлийн ашиглалтын төлөвлөгөөнөөс 167.6 тэрбум төгрөгөөр багаар тооцоологдож байгаа юм. Иймд зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төлөвлөсөн 497.7 тэрбум төгрөг 330.1 тэрбум болж 167.6 тэрбум төгрөгөөр буурч байна.

Төлөвлөсөн хэмжээ буурч буйн шалтгаан нь БНХАУ-ын 500.0 сая ам.долларын төслийн зориулалт өөрчлөгдсөн тул төлөвлөсөн 98.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийх боломжгүй болсон. БНСУ-ын Үндэсний оношилгоо шинжилгээний төв байгуулах төслийн гүйцэтгэгч компани сонгогдоогүйгээс төлөвлөсөн 8.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гаргах боломжгүй болсон. АХБ-ны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх 3 төсөл соёрхон батлагдаагүй бөгөөд одоо хэрэгжиж буй “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн барилгын ажил хойшлогдсонтой холбогдуулан төлөвлөсөн 60.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулах боломжгүй болсон байна.

Засгийн газрын бонд: а. Улсын Их Хурлын 2011 оны “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны “Засгийн газрын үнэт цаас гаргах тухай” 208 дугаар тогтоолын хүрээнд ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгоход зориулан 100.0 /нэг зуун/ тэрбум төгрөгийн, хонины ноос, тэмээний ноос бэлтгэгчид болон

Үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 50.0 /тавин/ тэрбум төгрөгийн, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд зориулан 150.0 /нэг зуун тавин/ тэрбум төгрөгийн, нийт 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалсан билээ.

Арилжаалсан үнэт цаасны эх үүсвэрээс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 290.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 5 жилийн дараа буюу 2016 онд төсөвт буцаан төлөх нөхцөлтэйгээр зээлдүүлсэн. Үлдэж буй 9.9 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал хэлбэрээр олгосон юм.

Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолоор үнэт цаасыг 5 жилийн хугацаатай арилжаалахыг даалгасан боловч зах зээлийн тухайн үеийн нөхцөл байдлын улмаас харьцангуй богино буюу 1-2 жилийн хугацаатай арилжсан. Энэхүү нөхцөл байдлын улмаас төсөвт ирэх ачаалал нэмэгдэж байгаа тул Улсын Их Хурлын 30 дугаар тогтоолд заасан хугацаатай нийцүүлэх, зээлдэгч нараас улсын төсөвт эргүүлэн төлөх хуваарьтай уялдуулах зорилгоор 290.1 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гаргах саналтай байна.

б. Улсын Их Хурлын 2012 оны “Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” 28 дугаар тогтоолын хүрээнд улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан 270.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг 2012 оны төсвийн жилд гаргаж, арилжаалахыг даалгасан.

Үүнээс 180.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний Засгийн газрын үнэт цаасыг урт хугацаатай арилжаалах байсан боловч зах зээлийн тухайн үеийн нөхцөл байдлын улмаас богино хугацаатай арилжигдаж 2013 оны 7 дугаар сард бүрэн төлж барагдуулсан. Энэ нь 2013 оны улсын төсвийн нийт санхүүжилтэд нөлөөлж байгаа тул 180.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг нэмж он дамжуулан гаргах саналтай байна.

в. Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.2-т “Төсөл, арга хэмжээний онцлогоос шалтгаалан түүнийг хэрэгжүүлэх мөчлөг нь төсвийн жилээс зөрүүтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулж болно” гэж заасны дагуу 2012 оны он дамжсан хөрөнгө оруулалтын 182.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2013 оны 3 дугаар сарын 31-ныг дуустал хугацаанд санхүүжүүлсэн болно. Энэ санхүүжүүлсэн хөрөнгө нь 2013 оны батлагдсан төсөвт тусгагдаагүй тул дутагдаж хөрөнгийн эх үүсвэрийг нөхөн бүрдүүлэх шаардлагатай байна.

г. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Шинээр гаргах болон дахин санхүүжүүлэх Засгийн газрын он дамжих үнэт цаас 812,476.2 сая төгрөг” байна гэж заасан. Засгийн газрын гаргах үнэт цаасыг дээрх байдлаар нэмэгдүүлсэн тохиолдолд 2013 оны төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан хязгаарыг 650.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1,462.4 тэрбум төгрөг болгохоор төсвийн тодотгосон төсөлд тусгалаа.

4. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд, төсвийн тэнцэл, эх үүсвэр

Монгол Улсын 2013 оны төсвийн тодотголын өөрчлөлтүүдийг тусгахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого **799.2 тэрбум төгрөгөөр** буурч 6,289.1 **тэрбум төгрөг**, нийт зарлага 814.8 **тэрбум төгрөгөөр** буурч нэгдсэн төсвийн нийт зарлага 6,629.8 **тэрбум төгрөг** болж,

нэгдсэн төсвийн нийт алдагдал 340.7 **тэрбум төгрөг**т хүрч **ДНБ-ний 2.0** хувьтай тэнцэхээр байна.

Төсвийн тодотголоор улсын төсвийн нийт орлого 666.1 тэрбум төгрөгөөр, нийт зарлага 809.5 тэрбум төгрөгөөр буурч, улсын төсвийн нийт алдагдал 143.4 тэрбум төгрөгөөр буурч **608.1 тэрбум төгрөг**т хүрэхээр тооцогдлоо.